



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/679

Булган сум

Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох
мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр
бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 81 дүгээр тогтоолоор баталсан "Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам"-ын 3 дугаар хэсгийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "СОНУ ОРШИХ" ХХК-г барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохих үйл ажиллагааг хуулийн дагуу эрхэлж, холбогдох тайлан, мэдээг хууль, журмын дагуу тайлагнаж байхыг "СОНУ ОРШИХ" ХХК (Ч.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010957